



ОРХОН АЙМГИЙН БАЯН-ӨНДӨР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН . . 8 . . ДАХЬ УДААГИЙН
СОНГУУЛИЙН ЭЭЛЖИТ . ХХ . ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2024 оны 08 сарын 10 өдөр

Дугаар 20/02

Эрдэнэт

Сонгуулийн зурагт самбарын
байршил тогтоох тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.3 дахь хэсэг, 41 дүгээр зүйлийн 41.9 дэх заалт, Газрын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь заалтыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл, нэр дэвшигчдийн сурталчилгааны нэгдсэн болон зурагт самбар байрлуулах байршлыг хавсралтаар баталсугай.

2. Иргэн, аж ахуй нэгж байгууллагын эзэмшил, ашиглалт, өмчлөлөөс бусад нийтийн эзэмшлийн газарт байршуулахыг Сумын сонгуулийн хороонд үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Сонгуулийн хорооны дарга Ш.Өлзийбаярт даалгасугай.

ДАРГА



Э.ЭРДЭНЭБАТ

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2024 оны 08 дугаар сарын 10-ны өдрийн
Ээлжит XX хуралдааны 20/02 дугаар
тогтоолын хавсралт

**ЗУРАГТ САМБАРЫГ НИЙТИЙН ЭЗЭМШЛИЙН ГУДАМЖ, ТАЛБАЙ, ОЛОН НИЙТИЙН
ГАЗАРТ БАЙРЛУУЛАХ БАЙРШИЛ**

1	Зэст	Нийтийн эзэмшлийн талбай
2	Оюут	Нийтийн эзэмшлийн талбай
3	Уурхайчин	Нийтийн эзэмшлийн талбай
4	Хүрэнбулаг	Нийтийн эзэмшлийн талбай
5	Уртбулаг	Нийтийн эзэмшлийн талбай
6	Согоот	Нийтийн эзэмшлийн талбай
7	Дэнж	Нийтийн эзэмшлийн талбай
8	Бүрэнбүст	Нийтийн эзэмшлийн талбай
9	Шанд	Нийтийн эзэмшлийн талбай
10	Наран	Нийтийн эзэмшлийн талбай
11	Цагаанчулуут	Нийтийн эзэмшлийн талбай
12	Булаг	Нийтийн эзэмшлийн талбай
13	Баянцагаан	Нийтийн эзэмшлийн талбай
14	Говил	Нийтийн эзэмшлийн талбай
15	Рашаант	Нийтийн эзэмшлийн талбай
16	Малчин	Нийтийн эзэмшлийн талбай
17	Эрдэнэ	Нийтийн эзэмшлийн талбай
18	Баянбулаг	Нийтийн эзэмшлийн талбай
19	Их залуу	Нийтийн эзэмшлийн талбай
20	Даваат	Нийтийн эзэмшлийн талбай
21	Уртын гол	Нийтийн эзэмшлийн талбай
22	Яргуйт	Нийтийн эзэмшлийн талбай
23	Найрамдал	Нийтийн эзэмшлийн талбай
24	Чандмань	Нийтийн эзэмшлийн талбай
25	Баян-Овоот	Нийтийн эзэмшлийн талбай
26	Чингэл	Нийтийн эзэмшлийн талбай



**ОРХОН АЙМАГ
ЖАРГАЛАНТ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2024 оны 08 дугаар сарын 10


Дугаар 01

Жаргалант сум

Ухуулах хуудас, зурагт самбарын
байршлыг тогтоох тухай

Монгол Улсын "Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль"-ийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх заалт, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.3, 40.5, дахь хэсэг, 41 дүгээр зүйлийн 41.9 дэх заалтуудыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит XV хуралдаанаас **ТОГТООХ** нь:

1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн сурталчилгааны ухуулах хуудас болон зурагт самбарыг сумын нутаг дэвсгэрийн хэмжээнд нийтийн эзэмшлийн гудамж, талбай, олон нийтийн газарт байршуулсугай.
2. Ухуулах хуудас, зурагт самбарыг байрлуулахдаа замын тэмдэг, тэмдэглэгээ, гэрлэн дохио, хөдөлгөөн зохицуулах бусад хэрэгслийг халхлах, бусдын эд хөрөнгө, явган зорчигчид аюул учруулж болзошгүй байдлаар байрлуулах, замын хөдөлгөөнд саад учруулахыг хориглосугай.
3. Тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг сумын Засаг дарга (Б.Зоригтбаяр)-д үүрэг болгосугай.



ДАРГА **ЖАЯТАНТӨГС**

6124010025